

Сүмбэ хамба Ишбалжирын уран бүтээлийн тойм

УСГАЛ*

*Монгол Улс, Улаанбаатар,
Монгол Улсын Их Сургууль,
Шинжлэх Ухааны Сургууль,
Утга зохиол, урлаг судлалын тэнхим*

Received: Aug 16, 2025 | **Revised:** Nov 12, 2025 | **Accepted:** Dec 04, 2025

Хураангуй: Сүмбэ Хамба Ишбалжир нь шашин, гүн ухаан, анагаах ухаан, одон орон зурхайн ухаан, уран зохиол зэрэг олон талын мэдлэгтэй нэгэн байсан бөгөөд түүний бүтээлүүд олон залуу эрдэмтдийн судалгааны суурь болж байна. Түүний сүмбүмд нийт найман боть, дал орчим бүтээл багтах бөгөөд үүний талаас илүү хувь нь буддын шашны онолд холбогдож байна. Ишбалжирын уран зохиолын хөгжилд оруулсан хувь нэмрийг олон судлаачид тодорхой дурдсан бөгөөд түүний сүмбүмд багтсан уран зохиолын болон уран зохиолд холбогдох бүтээлүүдийг онцлон дэлгэрүүлэв.

Түлхүүр үг: Сүмбэ хамба Ишбалжир, Ишбалжирын сүмбүм, зохист аялгуу, уран бүтээл, уран зохиол, найман боть, модон бар.

Overview of the Works of Sumbe Khambo Ishbaljir

USGAL

*Department of Literature and Arts
School of Arts and Sciences,
National University of Mongolia,
Ulaanbaatar, Mongolia*

Abstract: *Sumbe Khambo Ishbaljir was a scholar with knowledge in religion, philosophy, medicine, astrology, and literature, and his works have become a foundation for research by many young scholars. His sūmbūm (collection) includes a total of eight volumes and around a dozen works, more than half of which are related to Buddhist doctrine. Many researchers have highlighted Ishbaljir's contribution to the development of literature, emphasizing the literary works and related writings included in his sūmbūm.*

Key words: *Sumbe Khambo Ishbaljir, Ishbaljir's gsung 'bum, proper melody, artistic works, literature, eight volumes, wooden block.*

* © Усгал 2025
Email: 187054746@qq.com

1. Удиртгал

Энэхүү өгүүлэлд гурван настайдаа Лувсандамбийжанцаны хувилгаан дүр хэмээгдэн, долоон настайдаа Гонлүн хийдэд залагдан, “Номын маргааны сүргийн манлай” гэгдэж асан Сүмбэ хамба Ишбалжирын нэг насандаа бүтээн туурвисан таван ухааны бүтээлүүдийг он цагийн дарааллаар тоймлон хүргэхийг зорив. Ингэхдээ анагаах ухааны болон зурхай, он тооллын ухаанд холбогдох бүтээлүүдийг товч дурдан, уран зохиолд холбогдох бүтээлүүдийг түүвэрлэн бичихийн сацуу зарим түүхэн уран бүтээлүүд нь уран зохиолд хэрхэн холбогдож буй талаар өгүүлэх болно.

Энд нэгэн зүйлийг тэмдэглэхэд их хүмүүний бүтээлийг монгол хэлнээ буулгахдаа орчуулагч бүр өөр өөрийнхөөрөө ухан хөрвүүлсэн байх тул нэг бүтээлийн нэрийг хоёр гурван янзаар өгүүлж буй. Эдгээр нь эш татсан ном хийгээд материалд дурдагдсан янзаар байх бол эш татан хэрэглээгүй судлаачийн зүгээс оюун дүгнэлт хийсэн хэсэгт эрдэмтэн Л.Тэрбишийн хөрвүүлсэн “Сүмбэ хамба Ишбалжирын өөрийн намтар оршвой” дахь орчуулгаар бичсэн болно.

2. Судалгааны арга, эх хэрэглэгдэхүүн

Энэхүү өгүүлэлд эх бичиг сурвалж судлалын судалгаанд өргөн ашигладаг бүртгэн мэдээлэх, нэгтгэн дүгнэх зэргийг голлон хэрэглэсэн бөгөөд Сүмбэ хамба Ишбалжирын сүмбүм зохиолуудыг судалгааны эх хэрэглэгдэхүүн болгов.

3. Судалгааны хэсэг

Нэг. Ишбалжирын сүмбүм⁴⁵

Ишбалжир амьдрах хугацаандаа түүх, хэл, шашны онол, гүн ухаан, зурхай, эмнэлгийн ухаан, уран зохиол зэрэг 70 орчим зүйлийн зохиол бүтээл туурвиж өлзийт найман тахилтай дүйцүүлэн найман боть болгон эмхэтгэжээ. Энд 70 орчим хэмээн баримжаалан бичсэн учир нь одоогоор Сүмбэ хамба Ишбалжирын сүмбүм хэмээгдэн Төвөдөд хадгалагдаж байгаа бүтээл нь 71 байна. Эдгээрээс 2 гээгдсэн, 1 давхардсан, 1 буруу тэмдэглэсэн бөгөөд үнэндээ 69 байдаг. Боталад бол 65, Монголд 69 байдаг гэсэн тоо баримт бий хийгээд эрдэмтэн Л.Тэрбишийн тэмдэглэснээр 64, Өлзийн тэмдэглэснээр 66, Эрдэнэбаяны тэмдэглэснээр 71 (青格力, 2021: 125) бүтээл байна. Энд байгаа бүх хувилбарууд Устын зууд байгаатай ерөнхийдөө адилхан байна. Бусад өөр хувилбар олоогүй тул Устын зууд байгаа нь жинхэнэ гэж нотлох нэгэн үндэслэл нь энэ болдог байна.

Ишбалжирын сүмбүмийг түүнийг амьд сэрүүн байсан 1786 онд Гонлүн хийдэд найман боть болгон анх барласан. Энэ найман ботид нийт 71 зохиол багтан орсон бөгөөд (Шү Лин, 2016: 2-3) 2900000 үсэг байдаг. Харин 1975 онд Энэтхэгийн Шинэ Дэлд түүний бусад зохиолыг нэмэн 9 боть, 87 зохиолыг дахин барласан байна (Шү Лин, 2016: 2-3). Үүнд “Их цогт очир айлгагчийн анхдугаар зэргийн бясалгах хөтөлбөр нийт бусын шид бүхэн гарахуй хэмээгдэх оршвой” (225 хуудас), “Рашааны зүрхэн найман гишүүнтийн нууц увдис эрдмийн үндэсний нөхвөр, зовлонгийн халуун энэллийг арилгагч гадар, үес бусын үхлийн цалмыг таслагч хэмээгдэхийн арван долоон бүлэг” (нийт 17 зохиол, 755 хуудас)-ийг нэмж барлажээ. Хөх нуурын Хэйнан Жугийн Гүх Хэ Шэний 2012 оноос эхлүүлсэн “Сүмбэ Ишбалжирын сүмбүм”-ийг эмхэтгэн хэвлүүлэх ажил нь үндсэндээ дуусаж 9 боть 90 зохиолыг цуглуулаад байгаа бөгөөд 20 боть болгон хэвлүүлэх төсөвтэй гэдэг (Шү Лин, 2016: 2-3). Нийт бүтээлийнх нь 55 хувийг буддын

⁴⁵ Хуучны төвөд монгол эрдэмтэн мэргэдийн зохиосон бүрэн зохиолын эмхэтгэл.

шашны онолд холбогдох бүтээлүүд эзэлдэг бөгөөд Л.Тэрбишийн тэмдэглэснээр сүмбүм нь ka, kha, ga, nga, ca, cha, ja, нуа гэсэн найман боть буюу доорх 64 бүтээл багтсан байна.

Га /ka/

1. Хутагтын орон, Их Хар Хятад, Төвөд болон Монгол оронд дээдийн ном гарсан ёс сайн найлзуур модон хэмээх оршвой.

Ха /kha/

2. Үгсийн тийн ялгал, маш тодорхой толийн үндэс хийгээд түүний нарийн хадмал тайлбар маш тодорхой толь
3. Шалгадгийн долоон аймгийн зүрхэн шим хийгээд тогтсон тааллын тийн ялгалыг өчүүхэн хураасан нь
4. Эрхэм зарлигийн хүү сангийн зуун үүдийг нээгч түлхүүр хэмээх
5. Найман бодын далдын тоог удирдагч галбарваасан модны сүеэ хэмээх
6. Илт онолын чимгийн хатуу аньсны нийтийн утгыг өчүүхэн хураасан шинэхэн оюутны хүзүүний чимэг хэмээх
7. Хувраг хорьтын нийтийн утгыг хураасан
8. Төв үзэлд орохуйн хязгаарын шинжлэлийг өчүүхэн хураасан сарны гэрэл хэмээх
9. Эрхэм зарлигуудаас номлосон зарим нэгэн тоог удирдагчийг хураасан цэцгийн эрхэсийг арвижуулсан хэмээх

Га /ga/

10. Ламын лавшруулан барилдлага шид бүтээлийн хүү сан
11. Банчин их эрдэнэ Лувсанчойжичойжижалцаны ламын тахилгын зан үйлийн тайлбар төгс хувьтны хүзүүний чимэг
12. Дээр үгүй бодь явдлын дөт зам
13. Амарлин ахуй, үлэмж үзэл хослон барилдуулсан увдис бүхнийг хураасан
14. Төв хэтрүүлэгчийн ёсны үзлийн хөтөлбөр бичиг өчүүхэн дэлгэрүүлсэн амгалан жаргалангийн амтат шүүдэр
15. Төв үзлийн дунд хөтөлбөр сайн номлолын сарны гэрэл
16. Төв үзлийн машид товчлон хураасан хөтөлбөр залуу оюунтны чихний чимэг
17. Билгийн зүрхний бүтээлийн арга үйлийн барилдлага сэлт харанхуйг арилгагч зул
18. Жодын товч үгийн нарийн хадмал тайлбар сэлт бүхнийг айлдагчийн сайн мөр
19. Гүр дуулал хөхөөн яруун дуу тэргүүтэн
20. Гэтлэхийг хүсэгч төгс оюунтан бээр ашдын дуршлыг бүтээх ёсны өчүүхэн товъёг буяныг дуртгагч дуун эгшиг
21. Оюун судлахуй далан долоот эхийн өнцгийн гүйцээлт лүгээ сэлтийн үндсэн үгсийн нарийн хадмал тайлбар дээд хөлгөний шинийн саран

А /nga/

22. Дандарын аймгийн далайн сал онгоц
23. Цогт очир айлгагч арван гурван бурхантын уншлагыг товчлон хураасан хос орлогын дөт мөрт
24. Насан яндашгүй бурхны үүднээс насны үрэл бүтээхийн ёс рашааны насны үргэлжлэл
25. Бүхнийг ухагч тийн бөгөөд гэгээн зохиогчдын зан үйл, авшиг сэлтийг маш товчлон хураасан ариудан гэтэлгэх алтан гүүр
26. Ялж төгс нөгчсөний гурван тангаргийг байгуулсан хааны бүтээх арга хийгээд түүний үүднээс чилэн ахуй ёсны зан үйл сайн буяны шат
27. Хутагт цагаан шүхэртийн бясалгал бүтээх үйлийн чуулганыг үйлдэх хотол чуулган алин санасныг өгөгч
28. Лагшин, зарлиг, тааллын шүтээний тиг зургийн үндэсний нарийн хадмал тайлбар цэцгийн үзэсгэлэнт эрхэс
29. Газрын шинжлэх, газар авах, газрын үйл гурвын хумх санд нуух лугаа сэлтийн гарын авцыг товчлон хураасан удвал цэцгийн баглаа

30. Хот мандлын газрын зан үйлийн бүжиг хийгээд тахилын бүжгийн гарын авц онц гайхамшигт дуу бүжиг
31. Лагшин зарлиг тааллын шүтээнд амиллыг үйлдэхийн ёс дэлгэр, дунд, хураангуй гарын авц гишүүн лүгээ сэлт сайн буяны адис буулгагч
32. Дөрвөн дандар тус тусын өглөгийн түллэгийн гарын авцыг товчлон хураасан шид бүтээлийн усны урсгал
33. Шарил хайлан ёсны гарын авц тус амгалангийн яруу номын үгс
34. Зуурдын хавцгайгаас гэтэлгэгчийн үгийн тайлбар өчүүхэн хураасан сайтар удирдагч морин тэрэг
35. Сухавадийн ерөөл ариун орны дөт зам
36. Балингийн зан үйлийн дөрвөн үйлийг сүндлэн бүтээх хэмээх
37. Махагал дөрвөн бурхны хонхны бүтээлийн увдис есөн хүслийн эгээрлийг хангагч хийгээд бясалгал, бүтээл, үйл гурав тэргүүтний тийн агууллыг товчлон хураасан хоёрдугаар санасныг өгөгч
38. Хүү сангийн эзэн их ялагч Намсрайд сан тавин, балин өргөх ёс борыг баригч хүү сан
39. Таван сахиус тэргүүтний үүднээс ад тогторын хорлол хөнөөлийг хариулан сахин үйлдэх ёс их эрдэнийн зэр зэвсэг
40. Ариун эрхэм зарлиг усны хирийг арилгагч зэндмэнэ эрдэнэ

Жа /ca/

41. Ялгуусны эрхэм зарлиг бүгдийн увдисын шимийг тийн бөгөөд хураасан номын явдлын зэндмэнэ эрдэнийн эрхэс

Ча /cha/

42. Номын явдлын өчүүхэн хураасан сайн хувьтны гэтлэх мөр

Жа /ja/

43. Тосон эм.
44. Сэлбэрүүлэн шинжлэх рашааны урсгалын гишүүнээс гарын авцыг өчүүхэн хураасан рашааны цагаан шүүдэр
45. Эмийн хураангуй.
46. Эм шинжлэлийг машид өчүүхэн хураасан рашааны баяр хурим
47. Сэлбэрүүлэн шинжлэх рашааны урсгалын гишүүний дотоод аймгийн эм тус бүрийн илт өгүүлэх нэр хийгээд танин барихуй арга цагаан болор толь одон, хар зурхайн шимийг өчүүхэн хураасан бүхнийг гийгүүлэгч толь
48. Одон, хар зурхайн шимийг өчүүхэн хураасан бүхнийг гийгүүлэгч толь
49. Зурхайн шастир бүхнийг хураасан толийн хөвгүүн шүн сэрүүн сарны шимийн найрлага төгс буянт шинэ зурхай
50. Төгс буянт шинэ зурхайн шороон зургийг зурах ёс хийгээд махбодын зурхайн хүснэгт
51. Ойрад нутагт дэлгэрсэн хонины дал үзэх төлгө илбэ хувилгааны эш бошго
52. Үгийн чимэг өчүүхэн хураасан зохист аялгуунд орох үүд
53. Зохист аялгууны толиос номлосон чимгүүдийн өгүүлэл нагчадарын үзэсгэлэнт эрхэс хийгээд нэрийн илт өгүүлэхийг өчүүхэн хураасан зэндмэнэ унжлага
54. Үгсийг илгээх тэргүүтний тийн агуулал тод оюутны баяр хуримын үүдийг нээгч
55. Зарим нэг лам ноёдод илгээсэн захидал яруу номын үгсийн бийваа хөгжим
56. Айлтгалыг өргөх хос ёсыг ирүүлэгч бийваа хөгжим
57. Тэжээхүй ухааны увдисыг машид хураасан рашааны дусал
58. Сэлбэрүүлэн шинжлэхүй далайн зүрхэн шимийн товчлон хураасан рашааны урсгал

Ня /nya/

59. Ялгуусны шашны гол суурь тусаар тонилохын суртаалын горимыг товчлон хураасан цэцгийг машид мишээлгэгч
60. Зарим нэг хийдийн аймгийн цаазын бичиг авч огоорохын яруу зул
61. Зарим нэгэн бүтээлийн аймгийн хууль цааз ариудан гэтлэх алтан гүүр
62. Дотоод ухаан, томьёоллын ухааны шүнгийн зарим нэг эргэлзээтэй аньсны асуултын хариултыг нэгэн зүгт хураангуйлан бичсэн машид цагаан цолмон

63. Хамба эрдэнэ бандидад алдаршсаны явдал ёсыг өгүүлсэн дуу баригчийн шимийн авлага
64. Хур буулгах, сахих тэргүүтний увдис тэнгэр, газрын үзэсгэлэнт чимэг эдгээр болно.

Тэрээр өөрийн намтарт бичсэнчлэн хоёр удаа өөрөө сүмбүмээ засварлаж барласан байна. Эхнийх нь 1777 оны 2 сард өлзийт найман тахилаар бэлгэдэн найман боть, тавин бүтээлээ Хөхнуурт барласан бол хоёр дахь нь 82 настайдаа буюу 1786 онд сар шинийн уулзвар дээр дахин нэг удаа шинэчилж барласан байна. Түүний сүмбүмийн долдугаар ботид нь анагаах ухааны Рашааны ундрал, Рашааны цагаан шүүдэр, Рашааны дусал, Рашааны хурим гэх номууд байх бөгөөд эдгээрийг “Дөрвөн рашаан” хэмээн нэрийднэ. Тэдгээр зохиолыг Бээжинд төвөд хятад хоёр хэл хавсарсан модон бараар хэвлэж байсан байна.

Хоёр. Ишбалжирын уран бүтээлийн он цагийн дараалал

Ишбалжирын сүмбүм дэх бүтээлүүд их бага таван ухааны тухай, шашин хийгээд төр, гүн ухааны урсгалууд, түүх, намтар, хэл уран зохиол, зан үйл, найруулга, үг зүй, зурхай, одон орон, анагаах ухаан, сүм хийдийн сахилга, сургалт зэрэг өргөн агуулгыг хамарчээ. Судлаач Шү Лин “Ишбалжир бол төвөд ба монгол эрдэмтдийн дотор үргэлжилсэн үгийн зохиолд хос төгөлдөр чимэг зэргийг туршиж хэрэглэсэн цөөн тооны эрдэмтдийн нэг мөн” гэж тодотгожээ. Ийнхүү Сүмбэ Хамба Ишбалжирын бүтээл туурвилыг бусад сурвалж бичигт дурдсанчлан бичсэн оноор нь он цагийн дарааллаар авч үзье.

“Гүр дуулал арслангийн яруу үг” хэмээх зохиолоо 1729 онд бичсэн тухай өөрийн намтарт тэмдэглэсэн байдгаас түүний бүтээл туурвилын зам эхэлжээ. Мөн оноос “Дуун галбингын эгшиг” хэмээх бүтээлийг туурвин таван ухааны тухай, 1736 онд зохист аялгууг тайбарласан алдарт “Зохист аялгууны толиос номлосон чимгүүдийн өгүүлэл нагчадарын үзэсгэлэнт эрхэс хийгээд нэрийн илт өгүүлэхийг өчүүхэн хураасан зэндмэнэ унжлага” бүтээлээ, 1740-өөд онд “Зохист аялгууны чимгийн үлгэр”, 1747 онд “13 дугаар жарны гал туулай жил бичсэн зурхайн гол төгс буян шинэ зурхайн эх хөвгүүн судар”, 1748 онд “Тарнийн нийтийн утга”, “Номын гарлага огоот хураасан сайн галбарваасан модон”, 1750 онд “Бодь мөрийн хялбар мөр”, 1752 онд рашааны нэршилт анагаахын дөрвөн ном, 1755 онд “Хар зурхайн шимийн эрдэнийг өчүүхэн хураангуйлсан хамгийг тодотгогч толь хэмээх оршвой”, 1777 онд “Дуун баригчийн тэжээл үгсийн чимгийн өчүүхэн хураангуй зохист аялгуунд орох үүд”, 1778 онд залуу лам хуврагуудад зориулан ном бүтээл бичиж байсан бол 1779 онд буюу шороон гахай жилд бүтээлийг нь анх барлажээ.

1782 оноос өөрийн намтрыг эхэлж бичсэн бол тус онд Хөхнуурын домгийг нь Хөхнуурын Ардын хэвлэлийн хорооноос төвөд хэлээр хэвлэсэн байна. Мөн зохиол нь 1983 онд хятад хэлээр орчуулагдаж Хөхнуурын үндэсний дээд сургуулийн сонинд нийтлэгдсэн (德. 孟克巴特尔, 1991: №2) ба англи, орос хэлээр орчуулагдан хэвлэгдэж байсан. Насан эцэслэхээс нь хоёр жилийн өмнө буюу 1786 онд бүх зохиол нь хэвлэгдсэний найр болж байжээ.

Гурав. Уран зохиолын болон уран зохиолд холбогдох бүтээлүүд

Сүмбэ хамбын өөрийн намтар нь төвөдөөр “*mkhan-po e rie-ni panti-tar grags-pa'i spyod tshul brjod pa sgra 'dzin bcud len zhes bya ba bzhugs-so*”. Монголоор “Сүмбэ Ишбалжирын өөрийн намтар оршвой” буюу “Эрдэнэ бандида Сүмбэ хамбын өөрийн намтар”. Тэрээр өөрийн намтрыг шороон бичин жил (1788 он) нас сүүдэр наян дөрөв хүртлээ 241 хуудас бичиж, залгуулан түүний шавь Төрөл билигт цорж Лувсангэлэг, Равжам Гэлэгсамдав 258-р хуудас хүртэл гүйцээн 1795 онд дуусгажээ. Тус намтрын төгсгөлд Сүмбэ хамбын 73 настайдаа бичсэн нэгэн товч өгүүллийг дагалдуулал болгон

бичжээ. Сүмбэ хамба чадамгай эзэмшсэн төвөд хэлээрээ тун яруу сайхан бичсэн энэхүү өөрийн намтартаа зөвхөн өөрийн амьдралаар зогсохгүй амьдарч байсан цаг үеийнхээ монгол, хятад, төвөдийн түүхийн баялаг агуулгыг бичиж оруулсан байна (Бира, 2020: 31).

Ишбалжирын намтар зохиол, гүр дуу, захидал бичиг зэрэг нь монгол уран зохиолд нэгэн зүйлийн уран туурвилын үлгэр жишээг үзүүлжээ. Ишбалжирын өөрийн намтар нь түүх, уран зохиол, үзэл санаа, эрдэм ухааныг багцлан багтаасан юм.

“Зохист аялгууны толиос номлосон чимгүүдийн үлгэр өгүүлэхүй одон мичдийн үзэсгэлэнт эрхэс ба илт өгүүлэхүй нэрийн товч хураангуй чандманийн унжлага хэмээгдэх оршвой”, “Үгсийн чимгийн өчүүхэн хураангуй зохист аялгуунд орох үүд” гэх энэхүү хоёр бүтээл бол Дандины зохист аялгууг судалсан монгол үндэстний алдартай сонгодог бүтээл мөн хэмээн эрдэмэд үздэг. Онцолж дурдахын учир нь шүлгийг шүлгээр задлан тайлбарласан нэн сонирхолтой бөгөөд агуулга нь бурхан шашин, шүлэг зүй, түүх судлал, бурхан шашныг хамарсан бүтээл юм.

Эрдэмтэн асан А.Эрдэнэбаяр Ишбалжирын шүлэг зүйн судлал бүтээлдээ түүний талаар “Ишбалжир шиг дотоод сэтгэлийн хөгжил хувирлаас болсон гадаад байдлын есөн дүрийг өгүүлэгдэхүүн амьд оруулан өгүүлсэн эрдэмтэн төвөд монгол эрдэмтний дунд бараг байхгүй. Үүнийг бид Ишбалжирын гавьяа зүтгэл гэж нотлууштай. Утга зохиолын онолын энэхүү чухал асуудлыг Ишбалжир 300 жилийн өмнө тодорхой дурдсан нь бидний сонирхлыг онц татна” хэмээн дурдсан байна.

Сүмбэ хамба өөрийн бүтээлүүддээ зохист аялгууны утга агуулгын тухай, үзүүлэх үр нөлөө, ач холбогдлын тухай, бичин туурвихуй хийгээд бичин туурвихуйн алдаагаа хэрхэн залруулах тухай асуудалд өөрийн хариултыг дэвшүүлсэн байна. Зохист аялгууны талаар бичсэн нэгэн захидлыг жишээлбэл:

Түүний тулд Дандины сайн онолын бүрдээр сайтар үүсгэсэнээс

Холболт сайн Галбарвас модны машид мурилзсан онжид нэрийн навчсын наран дунд

Утга төгөлдөр сайдын сайн үнэр ханхлан оргилсноор

Саруул оюутдын зургаан хөлтний суулганы баяр хуримын дуун өргөмү. (Шү Лин, 2016: 197)

Түүний амьдралын утга зохиолтой холбогдох хэсгийг зөвхөн шүлэг зохион өгүүлэхээр төсөөлөх боломжгүй юм. Тэрээр өөрийн сүмбүмд утга зохиолын онолын тухай зохиолуудыг багтаасан байх бөгөөд энд түүний **tshig rgyan nyung ‘dus snyan ngag ‘jug sgo bzhugs so, snyan ngag me long las bshad pa’i rgyun rnamс kyi dper brjod rgyu skar phreng mdzes dang mig mngon bjrod nyung ‘dus tsinda ma ni’i do shal zhes bya ba bzhugs so** (1736 он), **yig bskus sogс kyi rnam bzhag blo gsar dga’ ston sgo byed ces bya ba bzhugs so, blo dpon ‘ga’ zhis la bskur ba’i chab shog gtam snyan pa’i wang bzhugs so** зэрэг бүтээлүүд мөн багтсан байдаг (Pubayev, 1981: 14-23). Эдгээр бүтээл дотроос “snyan ngag me long las bshad pa’i rgyun rnamс kyi dper brjod rgyu skar phreng mdzes dang mig mngon bjrod nyung ‘dus tsinda ma ni’i do shal zhes bya ba bzhugs so” бүтээл нь монгол үндэстний дотроос хамгийн анхны шүлэг зүйн онолын тусгай бүтээл болсон байдаг.

Ишбалжирын бүтээлүүд дотор хамгийн алдартай бүтээл нь буддын ухааны түүх болох “Галбарваасан мод хэмээх шашны түүх” ном юм. Тус бүтээлээ 13 дугаар сайтар гарсан шар луу жилд (1748 онд) Гонлүн хийдэд туурвижээ. Уг ном нь Хөх хотноо модон бараар хэвлэгдэж, Сүмбэ хамбын сүмбүмийн тэргүүн ботид орсон. Энэхүү номыг 1908 онд эрдэмтэн Чандра Дас

(Chandra Das, 1908) англи хэлээр нийтлэн таниулсан болно. Гэвч энэ хувилбарт монгол, хятад хэсэг нь орхигдсон байсан тул 1959 онд эрдэмтэн Локеш Чандра (Lokesh Chandra) нөхөн хэвлүүлжээ. Тэрээр “Галбарваасан мод хэмээх шашны түүх” бүтээлдээ их бага таван ухааны агуулга үндэслэлийг, “Сүмбэ Ишбалжирын өөрийн намтар оршвой” зохиолд их бага таван ухааны ухагдахуун хийгээд ач тусыг, “Захидал бичиг тэргүүтний тийн агуулал” номдоо ухааны орны тойм агуулга, тэдгээрийн хоорондын харьцааг шинжилсэн байжээ.

“Ишбалжирын бурхан шашны түүх” гэх нэрээр хэвлэгдэж байсан Галбарваасан мод хэмээх шашны түүхийн монгол орчуулгынх нь тухай Өвөр монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн эрдэмтэн Чойжи “Монгол түүхэн тулгуур бичгийн товч тайлал” гэх өгүүлэлд анх танилцуулсан (1986: 6 дугаар хугацаа) байдаг. Мөн Хятадын Төвийн Үндэстний дээд сургуулийн дэд профессор Ч.Хишигтогтох “Монгол, Хятадаар зохиогдсон монгол судлалын бүтээлүүдийн тойм”-д нэг ботийг нь хэсэгчлэн (1987: 5 дугаар хугацаа) танилцуулсан. Одоогоор энэ бүтээлийн тухай гурван зүйлийн уйгаржин монгол орчуулга⁴⁶ байна. 1991 оны 4 дүгээр сард Өвөр монголын ардын хэвлэлийн хорооноос ӨМӨЗО-ны орны номын санд хадгалагдаж буй орчуулгыг Цэнгэл, Мү Божу нар харгуулан тайлбарлаж хэвлэсэн. Сүмбэ хамба Ишбалжир нь энэхүү номыг бичихдээ хятад, монгол тулгуур бичиг, төвөдийн эрдэмтдийн бүтээлүүд⁴⁷, ардын үлгэр домог, хутагт хувилгаадын намтар зэргийг дэлгэрэнгүй ашиглажээ.

Тус бүтээлийн агуулгыг доорх таван ерөнхий хэсэгт хуваан үздэг.

- Бурхны заларч ирсэн жич дээд номыг баригчийн түүх
- Буддын шашин Энэтхэгт үүсэж дэлгэрсэн түүх
- Төвөдийн буддын шашны түүх
- Хятадын буддын шашны түүх
- Монголын буддын шашны түүх

Энэхүү зохиол нь хэд хэдэн онцлог шинжийг агуулж байна. Тэр нь тухайн үеийнхээ бусад шашны түүхүүдтэй харьцуулахад Энэтхэг, Төвөд, Хятад, Монгол оронд шашны дэлгэрсэн байдлыг том зургаар харуулсан бөгөөд цаг хугацааны хувьд галав ертөнцийн үүслээс бурхны шашин буй болсон, түгэн дэлгэрсэн маш урт хугацааг хамруулан бичсэн байдаг. Бурхны шашны онол номлол хийгээд гүн ухааны талаар тогтолцооотой шинжлэн туурвисан нь мөн нэгэн онцлог билээ. Энэхүү шашны түүхийн талаар нэгтгэн дүгнэвэл дээр дурдсанчлан олон зүйлийн домог, түүхээс эшлэн бичигдсэн ч бичээч өөрийн үзэл санаа, байр суурь, шашинд хандах хандлагаа урнаар шигтгэн баяжуулж өвөрмөц бүтээл болгож чадсан байна.

Академик Ц.Дамдинсүрэн XVIII зууны үед Хөхнуурт монгол эрдэмтэн Сүмбэ хамба гарч, уран зохиолыг гарамгай судалж, төвөд монгол Гэсэрийн туужийн талаар маш сонирхолтой хоёр санал хэлсэн (Монголын уран зохиолын түүх, 2016: 15-16) хэмээн тэмдэглэсэн байна. Түүний Гэсэрийн талаар бичсэн баримт сэлт сүмбүмийнх нь, хамгийн сүүлийн буюу захидал харилцааны бичгүүд дунд буй. 1779 онд Банчин Балдан-Иш Төвөдөөс Хятадад очих замдаа Амдогийн өвгөн эрдэмтэн Сүмбэ хамбад тусгай захидал бичиж Гэсэр хаан хаана, хэдийд ямар хүн байсныг тайлбарлан өгөхийг гуйжээ. Тэгээд Сүмбэ хамба, Балдан-Ишид илгээсэн захидалдаа бичсэн нь: “Гэсэрийн түүх нь, жишээлбэл: Хятадын Тансан ламын намтартай адил.

⁴⁶ Нэгдүгээрх нь 19 дүгээр зууны сүүлч, Буриадын Дэлгэр хэмээх ламын 2 дэвтэрт хэсэгчилсэн орчуулга, хоёрдугаарх нь 1958 онд Өвөр монголын түүх, хэл бичиг судлах газраас хэвлэсэн Шинэрофийн хэсэгчилсэн орчуулга, гуравдугаарх нь ӨМӨЗО-ны орны номын санд буй орчуулагч болоод орчуулагдсан он цаг нь тодорхойгүй орчуулга.

⁴⁷ Хөх дэвтэр, Бүдэний Чойжин, Гунгаадоржийн Улаан дэвтэр, Лигба болон Шаравын Гэгээн толь, Тавдугаар далай ламын бүтээлүүд зэрэг олныг ашигласан тухайгаа тэмдэглэн бичсэн буй.

Тансан ламын намтар үнэн бодитой биш боловч одоо цагт их эзний өмнө түүний түүх зэргийг бүжиглэн дуурайж үйлддэг байна. Тэрчлэн Гэсэрийн түүх бол хэтэрхий өргөмжилсөн буюу уран яруу үгийн зохиол алин боловч элдвээр ярилцдаг. Гэсэрийг Дэргийн газрын зүүн хэсэг болох Хам-дод ба Лингийн газарт жаргалант Нимагацалд төрсөн гэдэг. Гэсэр хэдийд гарсан цагийг магадлан судалж эс мэдсэн боловч хэтэрхий эрт урьд цагт гарсан биш бөгөөд түүний нум тэргүүтэн ба ач жич нар ч хүртэл одоо Хамын оронд бий” (Дамдинсүрэн, 1957: 56-57) гэжээ.

1736 онд утгын 35 чимэг, язгуур, үйл, эрдэм, эд гэх дөрвөн чанарыг товойлгон бичдэг тухай өгүүлсэн “Зохист аялгууны толиос номлосон чимгүүдийн үлгэр өгүүлэхүй одон мичдийн үзэсгэлэнт эрхэс ба илт өгүүлэхүй нэрийн товч хураангуй чандманийн унжлага хэмээгдэх оршвой” гэх бүтээлээ туурвисан бөгөөд энэхүү бүтээлдээ Сүмбэ хамбаас зохист аялгууг тайлбарласан бөгөөд өөрийн зүгээс зохих гаргалгааг гаргаж ирсэн монгол уран зохиолын анхны шүлэг зүйн онолын ном юм. Үүн дотор “Үгсийн чимгийн өчүүхэн хураангуй зохист аялгуун дор орох үүд оршвой”, туурвигчийн бүрэлдүүлбэл зохих нөхцөлийг дурдсан “Номын явдлын өчүүхэн хураангуй сайн галавын гэтэлгэх мөр хэмээгдэх оршихуй”, “Хамба эрдэнэ бандида хэмээн алдаршсаны явдал ёсыг өгүүлсэн дуун баригчийн тэжээл хэмээгдэх оршвой”, “Захидал бичиг тэргүүтний тийн агуулал, шинэ оюунтны баяр хуримын үүдийг нээхүй”, бурхны шашны туурвигчид байваас зохих гурван нөхцөлийг дурдсан “Дотоод утгын нэр томьёоны ухааны голын зарим нэгэн сэжигтэй асуултад хариулсныг нэгэн зүг дор бичсэн маш цагаан сугар гараг хэмээгдэх оршвой”, “Зарим нэгэн лам ба ноёдод өгсөн захидал бичиг яруу үгсийн бийваа хэмээгдэх оршвой⁴⁸”, “Айлдал өргөх эш ёсныг барин ирүүлэх бийваа хэмээгдэх оршвой”, “Түр дуу хөхөөний яруу аялгуу тэргүүтэн оршвой” зэрэг бүтээл байна.

Түүний онол зөвхөн шүлэг бичих тухайд яриад зогсохгүй утга зохиол гэж юу болох, утга зохиолын ур чадвар, зорилго ба онцлог шинж, утга зохиолыг хэрхэн туурвих зэрэг асуудлыг мөн дэвшүүлж, олон төрлийн баримт бичгийг бичих аргыг тайлбарлаж, зохиогчид тавигдах шаардлага буюу зохиогчийн ёс зүйн тухай өгүүлсэн нь бүтээлийн бичигдсэн цаг хугацааг харгалзан үзвэл тун онцлогтой юм (Шү Лин, 2016: 103). Сүмбэ хамбын өөр нэгэн алдарт бүтээл нь “Хөхнуурын домог” буюу “Хөхнуурын домог тэргүүтэн эсэруагийн шинэхэн яруу дуун” төвөдөөр *mtsho sngon gyi lo rgyus sogs bkod pa'i tshangs glu gsar snang zhes bya ba bzhugs so* юм. Энэхүү бүтээлийн орчуулгын уг эх нь одоогоор Гандан хийдийн Данзан-Осор гавжийн хувийн номын хадгаламжинд байдаг бөгөөд хуулбар хувь нь Монгол Улсын Үндэсний номын санд хадгалагдаж байна. Уг бүтээлээ Сүмбэ хамба 83 настайдаа буюу 1786 оны гал морин жилд ардын домог үлгэр, аман яриа, ихэс лам нарын намтраас улбаалан бичжээ. Сүмбэ хамбын энэхүү бүтээл нь түүхэн баримт сэлт, шашны тухай гэхээс илүүтэйгээр энгийн ардын аж ахуй, байр байдлыг яруу тодоор дүрсэлсэн, хэл найруулгын хувьд гарамгай сайн хэмээн судлаачид үнэлдэг. Хөхнуур үүссэн тухай хөхнуурын ард иргэдийн дунд өргөн тархсан домгийг багтаасан “Хөхнуурын домог” хэмээх нэгдүгээр бүлэг, Хөхнуур, Төвөд Манжид эзлэгдэхээс өмнөх түүхийг бичсэн “Хөхнуурын харьяат нутгийг захирч байсан хүмүүсийн тухай” хэмээх хоёрдугаар бүлэг, Хөхнуурын газар зүйн мэдээлэл, Хятад болон Зүүнгарын улсын шашин төрийн үйл хэрэг, XVII зууны эцсийн Халх, Ойрадын тэмцэл сэлтийг багтаасан хэсгүүдээс бүрэлджээ.

Сүмбэ хамба Ишбалжир 1777 онд “Замбуу тивийн ерөнхий номлол хөхөөн яруу дуун хэмээх оршвой” буюу төвөдөөр *'dzam gling spyi bshad dpyid kyi pho nya zhes bya ba bzhugs so* хэмээх 13 хуудас бүхий газар зүйн зохиолыг туурвижээ. Эдгээрээс түүнийг газар зүйн талаар бас багагүй мэдлэгтэй хүн байсныг харж болно.

⁴⁸ Яруу найргийн хэлбэрээр бичигдсэн захидал

4. Дүгнэлт

Сүмбэ хамба Ишбалжир нь өөрийн намтартаа ямар жилд ямар бүтээлийг жигдлэн дуусгаснаа хэд хэдэн газар дурдсан байгаа боловч намтарт өгүүлсэн нэрсээр түүний бүтээлүүдийг тооцоолон гаргах боломжгүй байна. Иймд бүх бүтээлийн нэгтгэлийг харж болох зүйл нь түүний сүмбүм хийгээд сүмбүмийнх нь талаарх бусад судлаачдын бичиж тэмдэглэсэн зүйлс байна. Энэхүү өгүүлэлд сүмбүмд багтсан бүтээлүүдийн талаар болон зарим бүтээлийнх нь бүтээгдсэн он цагийн дарааллыг нэгтгэв. Сүмбэ хамба Ишбалжирын уран бүтээл болон захидал тэргүүтнийг судлан бичсэн судалгаа шинжилгээний ажил нэлээд бий бөгөөд тэдгээрт багтсан мэдээллийг сайтар тулган нягтах нь дараа дараачийн судлаачдын нэгэн үүрэг ажээ.

Түүнчлэн эх бүтээлээс орчуулсан орчуулга, дүн шинжилгээ цөөнгүй хэдий ч нэг нэр нэршлийг олон хувилбараар орчуулан нэрлэсэн, Сүмбэ хамба өөрийн намтартаа бүтээлүүдийнхээ нэрсийг товч дурдсан зэргийг цаашид анхааран судлууштай байна.

Ном зүй:

Монгол хэлээр:

- Бира, Ш.** (2020). *Төвөдөөр бичсэн Монголчуудын түүхийн зохиол*. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо. Орчуулсан Дэн Хөгжилт. [Bira, Sh. Tövödөөр bichsen mongolchuudyn tүүkhiin zokhiol. [Mongolian historical literature of the XVII-XIX centuries written in Tibetan, Inner Mongolia People's Publishing House, 2020]
- Дамдинсүрэн, Ц.** (1957). *Гэсэрийн туужийн гурван шинж*. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо. [Ts. Damdinsuren, Geseriin tuujiin gурvan shinj. Three Characteristics of Geseri's Tale, Inner Mongolia People's Publishing House, 1957]
- Монголын уран зохиолын түүх, 13-17 дугаар зуун хүртэлх үе.* (2016), Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо. [Mongolyn uran zokhiolyn түүkh, 13-17 дугаар зуун khүrtelh үе. *History of Mongolian Literature: From the 13th to the 17th Century*, Inner Mongolia People's Publishing House, 2016]
- Сүмбэ хамба Ишбалжирын өөрийн намтар.* (2018). Орчуулсан Л.Тэрбиш. Улаанбаатар
- Шү Лин.** (2016). *Сүмбэ Хамба Ишбалжир*. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо. [Shu Lin. Sümbe khabma Ishbaljir, Inner Mongolia People's Publishing House, 2016]
- Шү Лин.** (2016). *Сүмбэ Хамба Ишбалжирын утга зохиолын туурвил зүйн онцлог*. Эх хэл соёл судлал-15. Улаанбаатар. [Shu Lin. Sümbe khabma Ishbaljiryn utga zokhiolyn tuurvil зүйн ontslog. Ulaanbaatar, 2016]
- Чойжи.** (1986). *Монгол түүхэн тулгуур бичгийн товч тайлал*. Social Sciences in Inner Mongolia, Chinese Edition, 6th issue. [Choiji. Mongol түүken tulguur bichgiin товch tailal, 1986]
- Хишигтогтох, Ч.** (1987). *Монгол, Хятадаар зохиогдсон монгол судлалын бүтээлүүдийн тойм*. Mongolian Language and Literature Journal, 5th issue. [Khishigtogtokh.Ch, Mongol khyatadaar zokhiogdson mongol sudlalyn бүteelүүdiin тойm, 1987]

Гадаад хэлээр:

- Chandra Das. *History of the rise, progress and downfall of Buddhism in India by Sumpa Khan-po Ye-se-pal-jor, the great historiographer and chronogist of Tibet*, edited by Sarah Calcutte, 1908.
- Pubayev, R.E. Stanley Frye. *The Historical Treatise dPag-bsam LJon-bzang by Sum-pa mKhan-po (1704-1788). Peculiarities in the Text and their Interpretation in Translation. The Tibet Journal 6 (1), pp 14-23, pp.17, (Library of Tibetan Works and Archives 1981).*
- 宗喀·漾正冈布 杨才让塔, 从安多、卫藏、北京、蒙古到五台山: 松巴班智达的社会与学术活动及对沟通藏汉满蒙文化的贡献, 西藏大学学报 (社会科学版) 2022 年第 3 期 (总第 151 期)

布达拉文物保护管理所. 布达拉宫典籍目录 (藏文) [M]. 拉萨: 西藏人民出版社, 1990: 346-349.

德. 孟克巴特尔, 松巴堪布. 益希班觉尔及其著作, 西北民族研究, 1991 年第二期.

松巴·益西班牙觉. 如意宝树史[M]. 蒲文成, 才让, 译. 兰州: 甘肃民族出版社, 2013: 3, 3.

藏文典籍要目编纂小组. 藏文典籍要目 (藏文) [M]. 西宁: 青海民族出版社, 1985: 395-397.

青格力, 松巴堪布·益希班觉 《文集》刻本与乌素图召木刻雕板, 青海民族研究, 2021-02-11.

青海省海南州. 共和县藏语委. 松巴益西班牙觉文集 (藏文) [M]. 西宁: 青海民族出版社, 2015.



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>